



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн “Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК-ийн
2021 оны санхүүгийн тайлан, техник эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/18/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | | |
|-----|-----------------------------------------------------------------------|----|
| 1. | Аудитын санал дүгнэлт | 3 |
| 2. | Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 5 |
| 2.1 | Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... | 5 |
| 2.2 | Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан | 6 |
| 2.3 | Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан | 6 |
| 2.4 | Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 7 |
| 2.5 | Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл..... | 7 |
| 3. | Санхүүгийн тайлангийн тодруулга | 7 |
| 3.1 | Байгууллагын үйл ажиллагаа..... | 7 |
| 3.2 | Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин..... | 8 |
| 3.3 | Нягтлан бодох бүртгэлийн бодлого | 9 |
| 4. | Аудитын тайлан..... | 11 |
| 4.1 | Ерөнхий зүйл..... | 11 |
| 4.2 | Дотоод хяналт..... | 11 |
| 4.3 | Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 11 |
| 4.4 | Материаллаг байдал | 12 |
| 5. | Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 12 |
| 5.1 | Шилэн дансны мэдээлэл..... | 12 |
| 6. | Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 12 |
| 7. | Дараагийн аудитаар анхаарах асуудал | 13 |
| 8. | Аудитын илрүүлэлт | 13 |
| 8.1 | Залруулсан алдаа | 13 |
| 8.2 | Төлбөрийн акт..... | 13 |
| 8.3 | Албан шаардлага | 13 |
| 9. | Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 0 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|-----------------------------------------------|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХК | Хувьцаат компани |
| ОНӨГазар | Орон нутгийн өмчийн газар |
| ТБОНӨТХ | Төрийн болон орон нутгийн |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

9089.03.16 № 01/263
Танай _____-ны № _____-т

“ХӨВСГӨЛ ЭМИЙН ЭРГЭЛТИЙН
САН” ХК-ИЙН ЗАХИРАЛ
Б.ЦЭРЭНДУЛАМ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.4, 8.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад болон бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн “Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Хувьчлах үйл ажиллагаа: Тайлант жилд “Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК -ийг хувьчлах ажлын бэлтгэлийг хангах, хувьчлах үндсэн зорилготой ажилласан байна. Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны 08 дугаар тогтоолоор компанийн 49 хувийг хувьчлах, хувьцааны 51 хувийг орон нутгийн эзэмшилд байхаар шийдвэрлэсэн байна. Энэ уралдаант шалгаруулалтад оролцогч байгаагүй тул уг шийдвэр хүчингүй болсон байна. Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2022 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 07 дугаар тогтоолоор эд хөрөнгийн үнэлгээний дуудлага худалдааны доод үнийг тогтоон Нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулахаар шийдвэрлэж, амжилттай хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ: Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК -ийн эд хөрөнгийг дахин үнэлэх ажлыг Хөвсгөл аймгийн ОНӨГазар зохион байгуулж, үнэлгээний зардлыг санхүүжүүлсэн байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 58 дугаар тогтоолоор хөрөнгийн энэхүү үнэлгээг баталгаажуулж 2021 оны хагас жилийн санхүүгийн тайланд тусгахыг даалгасан байна. Эд хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү/нэмэгдэл 172.8 сая төгрөг тайлант жилийн санхүүгийн тайланд туссан байна. Дахин үнэлгээний нэмэгдэл нь газар, эм барих эрх, тусгай зөвшөөрөл, барилгын үнийн өсөлттэй холбоотой ба харин машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программ хангамжийн үнэ буурсан байна. Дуудлага худалдаанд оруулсан эд хөрөнгөнд үндсэн хөрөнгөөс гадна 32.5 сая төгрөгийн үнэ бүхий бараа материал (эм, эмнэлгийн хэрэгсэл)-ын үлдэгдэл орсон байна.

Өр төлбөрийн өсөлт: “Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК -ийн өр төлбөр өссөн гол шалтгаан нь эм эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэгч томоохон компаниудад төлөх хуримтлагдсан өр төлбөр он дамжин өссөн, байгууллагын үндсэн үйл ажиллагааг 2022 оны 1 сарын 8-нд зогсоох хүртэл тооцсон сүүлийн саруудын цалин, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр нэмэгдсэнтэй холбоотой байна. Дээр дурдсан 07 дугаар тогтоолоор эд хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар хувьчлах үндсэн чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах, дуудлага худалдааны орлогоос тухайн компанийн өр төлбөрийг барагдуулахыг аймгийн Засаг даргад даалгасан байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудал

“Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК-ийн үйл ажиллагаа зогсож, хаалтын тайлан гарахын өмнөх санхүүгийн тайлан гарч байгаа тул шалгагдагч байгууллага аудиторын зөвлөмжийг хүлээн авч тайлант жилийн санхүүгийн тайлангаа залруулж дахин гаргалаа. Тайлант жилийн санхүүгийн тайлан нь шийдвэр гаргагчид, өмч эзэмшигчид чухал ач холбогдолтой тул санхүүгийн тайлан үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаж байхаар энэхүү тайланг гаргасан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын үйл ажиллагаа зогсож хувьчлагдаж байгаатай холбогдуулан тайлант хугацаанд татварын байгууллага хяналт шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтаар илэрсэн актын төлбөрийг санхүүгийн тайланд тусгасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|--------------------------------------------|------------------------|------------------------|
| Эргэлтийн хөрөнгө | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 4,198,596.55 | 14,358,748.32 |
| Дансны авлага | 33,418,279.22 | 11,038,098.02 |
| Татвар, НДШ-ийн авлага | 7,070,665.00 | 2,367,335.90 |
| Бусад авлага | | 312,000.00 |
| Бараа материал | 106,485,464.69 | 37,835,096.33 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | | |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 151,173,005.46 | 65,911,278.57 |
| Эргэлтийн бус хөрөнгө | | |
| Үндсэн хөрөнгө | 168,922,134.62 | 151,913,577.24 |
| Биет бус хөрөнгө | 29,484,973.48 | 203,022,691.63 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 198,407,108.10 | 354,936,268.87 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 349,580,113.56 | 420,847,547.44 |
| Дансны өглөг | 508,131,138.75 | 553,016,153.06 |
| Цалингийн өглөг | 385,922.00 | 17,409,894.00 |
| Татварын өр | 13,266,098.92 | 15,309,380.24 |
| НДШ-ийн өр | | 30,160,496.91 |
| Урьдчилж орсон орлого | 972,888.18 | |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 522,756,047.85 | 615,895,924.21 |
| Өр төлбөрийн нийт дүн | 522,756,047.85 | |
| Өмч - төрийн | 213,724,947.29 | 213,724,947.29 |
| - хувийн | | |
| Халаасны хувьцаа | | |
| Нэмж төлөгдсөн капитал | | |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 97,315,587.00 | 270,159,805.26 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | | |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 31,674,000.00 | 31,674,000.00 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | -515,890,468.58 | -710,607,129.32 |
| Өмнөх | -369,202,950.12 | -527,710,948.58 |
| Тайлант үе | -146,687,518.46 | -182,896,180.74 |
| Эзэмшигдийн өмч ба капиталын дүн | -173,175,934.29 | -195,048,376.77 |
| НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 349,580,113.56 | 420,847,547.44 |

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

| Үзүүлэлт | /төгрөгөөр/ | |
|----------------------------------------------|------------------------|------------------------|
| | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
| Борлуулалтын орлого | 1,062,097,603.88 | 606,565,090.88 |
| Борлуулалтын өртөг | 837,116,095.86 | 481,195,678.86 |
| Нийт ашиг (алдагдал) | 224,981,508.02 | 125,369,412.02 |
| Бусад орлого | 50,000,000.00 | |
| Борлуулалт маркетингийн зардал | 325,761,820.58 | 239,972,577.36 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 70,252,249.34 | 67,609,616.57 |
| Санхүүгийн зардал | 8,353,252.87 | 122,353.38 |
| Бусад зардал | 4,035,022.00 | 561,045.45 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | -13,266,681.69 | |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | -146,687,518.46 | -182,896,180.74 |
| Орлогын татварын зардал | | |
| Татварын дараах ашиг (алдагдал) | -146,687,518.46 | |
| Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал | -146,687,518.46 | -182,896,180.74 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | |
| Орлогын нийт дүн | -146,687,518.46 | -182,896,180.74 |

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | /төгрөгөөр/ | |
|----------------------------------------------------|-----------------------|-------------------------------------|---------------------------|------------------------|------------------------|
| | | | | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
| 2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 213,724,947.29 | 97,315,587.00 | 31,674,000.00 | -369,183,550.12 | -26,469,015.83 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлө | | | | -9,700.00 | -9,700.00 |
| Залруулсан үлдэгдэл | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | (146,687,518.46) | (146,687,518.46) |
| 2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 213,724,947.29 | 97,315,587.00 | 31,674,000.00 | -515,880,768.58 | -173,175,934.31 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлө | | | | -11,820,479.98 | -11,820,479.98 |
| Залруулсан үлдэгдэл | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | -182,896,180.74 | -182,896,180.74 |
| Дахин үнэлгээний нэмэгдэлийн хэрэгжсэн дүн | | 172,844,218.26 | | | 172,844,218.26 |
| 2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 213,724,947.29 | 270,159,805.26 | 31,674,000.00 | -710,607,129.32 | -195,048,376.77 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Үзүүлэлт | /төгрөгөөр/ | |
|---------------------------------------------------------------|-------------------------|------------------------|
| | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
| Мөнгөн орлогын дүн | 1,143,684,378.37 | 642,517,392.13 |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 758,245,982.49 | 642,517,392.13 |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 385,438,395.65 | |
| Мөнгөн зарлагын дүн | 1,190,103,317.67 | 632,357,240.36 |
| Ажилчдад төлсөн | 224,722,206.46 | 117,532,439.56 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 69,417,010.68 | 15,481,108.13 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | 795,681,007.93 | 394,995,081.29 |
| Ашиглалтын зардалд төлсөн | 1,349,210.00 | 15,983,052.74 |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 1,833,422.78 | 604,292.00 |
| Татварын байгууллагад төлсөн | 78,533,250.33 | 64,069,065.98 |
| Бусад мөнгөн зарлага | 18,537,209.50 | 23,692,200.66 |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | -46,418,939.30 | 10,160,151.77 |
| Төрөл бүрийн хандив | 50,000,000.00 | |
| <i>Мөнгөн зарлагын дүн</i> | 50,000,000.00 | 10,160,151.77 |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 50,000,000.00 | 10,160,151.77 |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 3,581,060.69 | 10,160,151.77 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 607,835.86 | 4,198,596.55 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 4,198,596.55 | 14,358,748.32 |

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| № | Үзүүлэлт | 2020 оны гүйцэтгэл | 2021 оны | | Зөрүү | Хувь |
|----------|-------------------------------|--------------------|------------|-----------|--------|------|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | Нийт орлого | 1,062.1 | 1,061.0 | 606.6 | -454.4 | 57.2 |
| | Үүнээс: Цэвэр борлуулалт | 1,062.1 | 1,061.0 | 606.6 | -454.4 | 57.2 |
| 2 | Нийт зардал | 1,208.8 | 1,090.0 | 789.5 | -300.5 | 72.4 |
| | в) Хөрөнгө оруулалт их засвар | 00 | 0 | 0 | 00 | 0 |
| 3 | Цэвэр ашиг, /алдагдал/ | -146.7 | -29.0 | -182.9 | 153.9 | 6.3 |

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК-ийн зорилго нь Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, эрүүл мэндийн бүтээгдэхүүнээр стандартын шаардлага хангасан орчинд орон нутгийн иргэд болон эрүүл мэндийн байгууллагад үйлчлэхэд оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, чанар стандартын шаардлага хангасан гоо сайхан, ариун цэврийн бараа бүтээгдэхүүн борлуулж болно гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд “Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

“Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК нь хувийн хэргийн 1710001011 дугаартай, регистрийн 4141962 дугаартай, 4772 кодтой үндсэн үйл ажиллагааны чиглэл нь “Гоо сайхан, ариун цэврийн барааны худалдаа” эрхлэхээр 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр үүсгэн байгуулагдсан байна.

“Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК-ийн 24 суманд үйл ажиллагаа эрхэлдэг харьяа эмийн сангууд нь Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслийн худалдаа эрхэлдэг байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 82 дугаар тогтоолоор “Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж дүрмийн 4.1-дэх хэсгийн “Компанийн зарласан хувьцаа нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 303,810 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ” гэснийг “Компанийн зарласан хувьцаа нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 213704 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ” гэж шинэчлэн баталсан байна.

“Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК -нийн ТУЗ нь 9 гишүүнтэй, ТУЗ-ын нарийн бичгийн даргатай, компанийн жилийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланд үнэлэлт дүгнэлт өгдөг, жилийн орон тоо цалин, бизнес төлөвлөгөө, төсвийг баталдаг, гүйцэтгэлийг хэлэлцдэг байна.

Одоогоор дарга, нягтлан 2 хүн компанийн өр авлагыг барагдуулах, хөрөнгийг хүлээлгэн өгөхөд туслах, тайлан тооцоог бэлтгэх ажлыг гүйцэтгэж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК -ыг Хөвсгөл аймгийн ИТХ -ын 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 в/-д “тухайн орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөх, татан буулгах санал боловсруулж Хурал, түүний Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлагыг Компанийн тухай хуулийн 78-р зүйлийн 78.1.-д заасны дагуу “Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүний олонхын саналаар сонгоно”, гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- 2021 оны 4 сарын 08-ны өдрийн “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”
- Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2021 оны 11 сарын 19-ны 01-р тогтоол
- Хөвсгөл аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 01 сарын 07-ны өдрийн 07-р тогтоол
- “Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 01, 02, 03 ,04, 12, 13 -р тогтоолууд

“Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК -ийн эд хөрөнгийг дахин үнэлэх ажлыг Хөвсгөл аймгийн ОНӨГазар зохион байгуулж, үнэлгээний зардлыг санхүүжүүлсэн байна. Энэхүү үнэлгээний үр дүнд 2021 оны эхэнд байсан 198.4 сая төгрөгийн биет ба биет бус хөрөнгийн дуудлага худалдааны доод үнийг 439.3 сая төгрөгөөр тогтоож Нээлттэй дуудлага худалдаа зарласан байна. Дуудлага худалдаанд оруулсан эд хөрөнгөнд үндсэн хөрөнгөөс гадна 32.5 сая төгрөгийн үнэ бүхий бараа материал (эм, эмнэлгийн хэрэгсэл) үлдэгдэл орсон байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2022 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Орон нутгийн өмчийг 2020-2022 онд хувьчлах үндсэн чиглэлийг баталсан байна. Энэ тогтоолоор “Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК-ийн үйл ажиллагааг 2022 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөр тасалбар болгон зогсоож компанийн эд хөрөнгийг Нээлттэй дуудлага худалдаагаар хувьчлах үндсэн чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах, дуудлага худалдааны орлогоос тухайн компанийн өр төлбөрийг барагдуулах, компани татан буулгах ажиллагааг зохион байгуулахыг Аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан-д даалгасан байна. Эд хөрөнгийн нээлттэй дуудлага худалдаа 2022 оны 01 сарын 16-нд хийгдсэн байна.

“Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК -ийн эд хөрөнгийг сум бүрээр 24 багц болгон ддуудлага худалдаанд оруулсан байна. Дуудлага худалдаагаар доод үнэ өсөж 1,384.0 сая төгрөг болсон байна. Гэхдээ одоогоор дуудлага худалдааны нийт орлого аймгийн өмч хувьчлалын дансанд бүрэн төвлөрөөгүй байна.

Дээрх шийдвэрийн дагуу компанийн үндсэн үйл ажиллагаа бүрэн зогссон байна. Одоогоор дарга, нягтлан 2 хүн компанийн өр авлагыг барагдуулах, хөрөнгийг хүлээлгэн өгөхөд туслах, тайлан тооцоог бэлтгэх ажлыг гүйцэтгэж байна.

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО

“Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---------------------------------------------------|----------------|-----------------|-------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 4.2 | 14.4 | 10.2 |
| БХХО | | | 0.00 |
| Авлага | 40.5 | 13.7 | -26.8 |
| Бараа материал | 106.5 | 37.8 | -68.7 |
| Биет хөрөнгө | 168.9 | 151.9 | -17.0 |
| Биет бус хөрөнгө | 29.5 | 203.0 | 173.5 |
| Нийт хөрөнгийн дүн | 349.6 | 420.8 | 71.2 |
| Өр төлбөрийн дүн | 522.8 | 615.9 | 93.1 |
| Богино хугацаат өглөг | 522.8 | 615.9 | 93.1 |
| Эздийн өмч | -173.2 | -195.1 | -21.9 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 349.6 | 420.8 | 71.2 |

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 14.4 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэл ЭМДС-аас авах эмийн хөнгөлөлтийн авлага 2.2 сая төгрөг, НӨАТ-ын авлага 0.2 сая төгрөг, өмнөх онуудаас дамжиж ирсэн сумын эмийн санч нараас авах авлага 11.4 сая төгрөг байна. Тайлант онд авлага 26.8 сая төгрөгөөр буурсан байна. Өр авлагыг тооцоо нийлж тулган баталгаажуулсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 37.8 сая төгрөг болж 68.6 сая төгрөгөөр буурсан нь компани татан буугдах, хувьчлагдах болсноос шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 416.7 сая төгрөг эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад бараа материал хүлээн авсан бол 485.5 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад бараа материал худалдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэснээр машин тоног төхөөрөмжийн үнэ, тавилга хэрэгслийн үнэ нийт 23.3 сая төгрөгөөр буурсан, харин барилгын үнэ 21.2 сая төгрөгөөр өссөн, тайлант хугацааны элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Биет бус хөрөнгө 173.5 сая төгрөгөөр өссөн нь газар эзэмших, ашиглах эрх, эм барих эрх, үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн эрхийг шинээр үнэлж бүртгэснээс шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 616.0 сая төгрөг байна. Үүнд бэлтгэн нийлүүлэгчид өгөх өглөг, 553.0 сая, цалингийн өглөг 17.4 сая, татварын өглөг 15.3 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 30.2 сая төгрөг байна. Өмч хувьчлалын шийдвэрээр компанийн энэ өрийг эд хөрөнгийн нээлттэй дуудлага худалдааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Одоогийн байдлаар эд хөрөнгийн дуудлага худалдааны орлого энэ өр төлбөрийг бүрэн төлөх боломжтой байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК-ийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТУЗ-ийн 2021 оны 02 дүгээр тогтоолоор “Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Үүнд:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн үзүүлэлт

Хүснэгт 2

/сая.төг/

| № | Үзүүлэлт | 2020 оны гүйцэтгэл | 2021 оны | | Зөрүү | Хувь |
|---|-------------------------------|--------------------|------------|-----------|-----------------|---------------|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө-нөөс | Төлөвлөгөөтэй |
| 1 | Нийт орлого | 1,062.1 | 1,061.0 | 606.6 | -454.4 | 57.2 |
| | Үүнээс: Цэвэр борлуулалт | 1,062.1 | 1,061.0 | 606.6 | -454.4 | 57.2 |
| 2 | Нийт зардал | 1,208,8 | 1,090.0 | 789.5 | -300.5 | 72.4 |
| | в) Хөрөнгө оруулалт их засвар | 00 | 0 | 0 | 00 | 0 |
| 3 | Цэвэр ашиг, /алдагдал/ | -146.7 | -29.0 | -182.9 | 153.9 | 6.3 |

Дээрх үзүүлэлтүүдэд нөлөөлсөн хүчин зүйлүүдийг товч тайлбарлан авч үзвэл.

Тайлант жилд “Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК -ийг хувьчлах ажлын бэлтгэлийг хангах, хувьчлах үндсэн зорилготой үйл ажиллагаа нь 2021 оны 3-р улирал хүртэл ажилласан байна.

Тайлант оны нийт орлогыг 1,061.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,090.0 сая төгрөгөөр, 29.0 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна.

Байгууллагын орлого төлөвлөснөөс 454.4 сая төгрөгөөр, зардал 300.5 буурсан байна. Энэ 2021 онд хувьчлах үйл ажиллагаа явагдсан, үндсэн үйл ажиллагаа зогссоноос шалтгаалжээ.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын ажил тайлант онд хийгдээгүй байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд гэрээгээр Төгс суурь стандарт аудит ХХК аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд нягтлан бодох бүртгэл холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төгс суурь стандарт аудит ХХК-ийн ахлах аудитор Д. Алтайбаяр, аудитор Г.Мөнхбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Г. Оюунгэрэл, Гүйцэтгэх захирал Т. Батсайхан нар хяналт тавьж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар анхан шатанд чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

“Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 2 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө сул байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Компани нь энэ онд хувьчлагдах бэлтгэл ажиллагаа хийж хувьчлах шийдвэр хүлээн авсан тул хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК -ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 481.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70-хувиар буюу 5.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т хамаарах орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 3 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК нь тайлант онд өр авлагатай холбоотой нийт 566.4 сая төгрөгийн 20 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 20 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8 дахь заалтын “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, зэрэг мэдээллүүдийг мэдээлээгүй байна

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

“Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК нь ТУЗ-ийн гишүүдэд олгосон цалин урамшуулалд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу албан татвар ногдуулан суутгаагүй 0.3 сая төгрөгийг өглөгөөр тусган залруулж санхүүгийн тайланд тусгасан болно.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийгээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэл, шилэн данстай холбоотой 27.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн байна. Тайлант жилд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 182.6 сая төгрөгийн алдаа гарсан нь өнгөрсөн оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгааг харуулж байна. Шилэн дансны тухай хуулийн заалтыг мөн хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая.төгрөг/

| /сая төгрөгөөр/ Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|-----------------------------|------------------------|------|---------|-----|-------|------|------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 4 | 27.9 | 0 | 0 | 4 | 27.9 | 0 |
| Нийт дүн | 4 | 27.9 | 0 | 0 | 4 | 27.9 | 0 |

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнаагүй байна. Өмнөх оны аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Авлагыг хаалтын санхүүгийн тайлан гаргахын өмнө барагдуулах ажлыг зохион байгуулах, татвар нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлсэн байх.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 749.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 182.6 сая төгрөгийн алдааг залруулж, 566.4 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага өгсөн.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 182.6 сая төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Богино хугацаат өр төлбөрийг 0.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасан
- Тайлант үеийн алдагдлыг 5.6 сая төгрөгөөр дутуу тайлагнасан
- Тайлант үеийн Эзэмшигчдийн өмчийг 3.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан
- Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлыг 0.11 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Өмчийн өөрчлөлтийн тайланд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 172.8 сая төгрөгийг орхиж тайлагнасан учир энэ тайлан зөрүүтэй. Дээрх шалтгааны улмаас балансын Эзэмшигчдийн өмчийн тайлан зөрсөн.

8.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

8.3 Албан шаардлага

1. “Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК-ийн 2021 онд нийт 566.4 сая төгрөгийн 20 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 20 мэдээллийг байршуулаагүй зөрчилтэй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”-ийг 7 хоногийн дотор мэдээлнэ гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх, Төрийн аудитын тухай хуулийн 20.3, 21.1 заалтыг дагаж мөрдөх албан шаардлага өгсөн.

8.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй болно.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Залруулаагүй алдаа

Өнгөрсөн оны мөнгөн гүйлгээний тайлан 9700 төгрөгөөр, өмчийн өөрчлөлтийн тайлан мөн хэмжээний зөрүүтэй байсныг залруулаагүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөг/

| Д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|------------------------------------------------------------------|-----------------------------------|------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------|--------------------------|-------|-----------|-------|-----|-----|-----------------|-------|-------------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | “ Хөвсгөл эмийн эргэлтийн сан” ХК | ХӨА-2022/18/НА-СТА-ОНА | Өмнөх онуудын аудитын зөвлөмжөөр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэлгүй, тайлант жилийн санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 182.6 сая төгрөгийн алдаа давтан гаргасан зөрчил илэрлээ. | Залруулсан алдаа | 1 | 182.6 | 1 | 182.6 | 0 | 0 | | | | | | |
| ДҮН | | | | | 1 | 182.6 | 1 | 182.6 | 0 | 0 | | | | | | |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал | | | | | | | | | | | | | | | | |
| | | | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлээгүй. | Албан шаардлага | 1 | 566.4 | | | | | 1 | 566,4 | | | | |
| ДҮН | | | | | 1 | 566,4 | | | | | 1 | 566,4 | | | | |
| НИЙТ ДҮН | | | | | 2 | 749.0 | 2 | 182.6 | 0 | 0 | 1 | 566.4 | | | | |